



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn

Аудит менежер Я.Самбууням

Утас:261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа

Утас: 260512 Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК

Цахим хаяг: info@growthfinance.mn

Web:www.growthfinance.mn

Гроут финанс Аудит ХХК, Баянгол дүүрэг 3 дугаар хороо,
Үйлдвэрийн бүс, Энгельсийн гудамж 11-191 тоот

Улаанбаатар хот



Агуулга

2. Аудитын тайлан.....	1
2.1 Оршил	1
2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл, зорилго, талуудын хүлээх хариуцлага	1
2.3 Компанийн зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн	2
2.5 Дотоод хяналт:	3
2.6 Төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7 Шилэн дансны мэдээлэл:	4
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:	6
2.10 Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	6
2.11 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:.....	7
2.11.1 Эрчим хүчний үр ашиг II төслийн хүрээнд хүлээн авсан тоног төхөөрөмжийн бүртгэл, тайлагналын талаар	7
2.11.2 Гэрээний дагуу тооцон бүртгэх зээлийн хүүгийн зардал, өглөгийн тухайд	7
2.11.3 Санхүүгийн байдлын тайлангийн тайлагнал, өр төлбөрийн ангиллын талаар	8
2.11.4 Жилийн үр дүнгийн шагналын тухайд.....	8
2.11.5 Бараа материалын худалдан авалтын талаар.....	9
2.11.6 Үндсэн хөрөнгийн худалдан авалт, бүртгэлийн тухайд	9
2.11.7 Тоног төхөөрөмжид хийсэн их засвар, түүний бүртгэл	9
2.11.8 Үндсэн хөрөнгийн элэгдэл	10
2.11.9 Үлдэгдэл өртөгтэй боловч ашиглагдахгүй байгаа хөрөнгийн тухайд	10
2.11.10 Дуусаагүй төслийн дансны үлдэгдэлийн тухайд	10
2.11.11 Худалдан авах үйл ажиллагааны тухайд.....	10
2.11.12 Шатахууны үлдэгдэл баталгаажуулах тухайд	11
2.11.13 Худалдан авсан шатахууны үнэ, тоо хэмжээний тухайд	11
2.11.14 Үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох сар бүрийн шагналт цалин	11
2.11.15 Хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан гэрээт ажилчдын тухайд	11
2.11.16 Бараа материалын зарцуулалтын өртөг	12
2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал:	12
2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:	12
2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	13
2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:	13
2.16 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	14
2.17 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3. Менежментийн захидал.....	15-24
4. Санхүүгийн тайлангууд.....	25-30
5.Залруулгын хүснэгт.....	31-33
7.Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	34-36
8.Хураангуй тайлан	37-43

2. Аудитын тайлан

2.1 Оршил

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал С.Анхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, аудит хийгдсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн бараа материалын худалдан авалт, зарцуулалтын өртөг тооцолт, бараа материалын насжилт, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагнал, тооллогын үр дүн, үйлдвэрлэлийн үр дүнгийн шагналын журам, худалдан авах үйл ажиллагаа зэрэг нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн явцад илэрсэн материаллаг бус алдаа зөрчлийн талаар зөвлөмж өгөв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан, аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл, зорилго, талуудын хүлээх хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар “Гроут финанс Аудит” ХХК аудит хийлээ. Аудитын код САГ/2018/34/СТА-ТӨҮГ

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, журам, бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 07-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Гроут финанс Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдөр “Гроут финанс аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Компанийн зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 1983 онд байгуулагдсан бөгөөд “Эрчим хүчний тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу тус компанид Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2004 оны 49 дүгээр тогтоолоор цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, 2006 оны 106 дугаар тогтоолоор цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлүүдийг олгосон. Компани нь эдгээр тусгай зөвшөөрлийн дагуу цахилгаан, дулааныг үйлдвэрлэж, түгээх үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус компани нь цахилгаан, дулааны эрчим хүчийг хамгийн бага зардлаар үйлдвэрлэн нийлүүлэх, эрчим хүчний үйлдвэрүүдийн хөгжлийг тодорхойлогч байх эрхэм зорилго тавин ажиллаж байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 67.3 хувь, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 60.3 хувийг дангаар хангадаг Монгол улсын эрчим хүчний хамгийн том үйлдвэр юм. Тус станцын харьяанд 3-20 км алслагдсан үнс хадгалах сан болон техникийн ус хангамжийн насос станц мөн түүнчлэн ахуй үйлчилгээний, инженерийн, лаборатори туршилтын төв зэрэг 66.7 га талбай бүхий 70 гаруй барилга байгууламж багтдаг.

2017 оны байдлаар нийт үндсэн ажилтан 1486, гэрээт 134 ажиллагсадтай байгаагийн 278 инженер техникийн ажилтан байна.


Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 35 дугаар тогтоолоор “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн хувьцааг 100 хувь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж байна.

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 12 дугаар тогтоолоор С.Анхбаяр томилогдон ажиллаж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн компанийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /СТА-А-5/



Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 93 горим, сорил гүйцэтгэв. /СТА-А-5-3/

Тухайн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимтой танилцахад санхүүгийн үйл ажиллагаандаа СТОУС болон Сангийн яамнаас баталсан заавар журмын хүрээнд өөрийн компанийн онцлогийг тусган боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг (НБББББ) захирлын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/71 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. 2017 онд энэхүү НБББББ-нд СТОУС болон хууль дүрмийн өөрчлөлтийг тусган шинэчилсэн бөгөөд НБББББ-т Сангийн яам, Эрчим хүчний яамны саналыг авч, тусган удирдлагаар батлуулан мөрдөхөөр ажиллаж байна.

Мөн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг ERP програмаар боловсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Энэхүү програм нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа төдийгүй худалдан авалт, төлөвлөлт, хүний нөөц, засвар, борлуулалтын модультай уялдан ажиллаж байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

2.5 Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь хяналтын албатай бөгөөд энэхүү албанд орон тооны 1 санхүүгийн хяналтын дотоод аудитор гүйцэтгэх захирлын баталсан “Санхүүгийн хяналтын дотоод аудиторын ажиллах журам”-ын дагуу төрийн өмч, санхүү нягтлан бодох бүртгэлтэй холбогдон гарсан стандарт, хууль, дүрэм, заавар, журам, холбогдох хууль эрх зүйн актуудыг мөрдлөг болгон тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, стандартыг мөрдүүлэх, санхүү бүртгэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлж арилгуулах үндсэн үүрэгтэйгээр ажиллаж байна.

Тус компанийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба аудитын явцад дахин хянахад санхүүгийн хяналтын дотоод аудиторын ажлын цар хүрээг бодитой тодорхойлж, орон тоог хянах нь зүйтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2017 онд 232,250.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 233,272.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Борлуулалтын орлогыг орлогын төрлөөр ангилан үзвэл цахилгаан эрчим хүч борлуулалтын орлого 193,952.2 сая төгрөг, дулааны эрчим хүч борлуулалтын орлого 39,320.6 сая төгрөг байна. Борлуулалтын орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзэхэд 16,491.9 сая төгрөг буюу 7.6 хувиар өссөн, төлөвлөгөөтэй харьцуулахад 1,021.9 сая төгрөг буюу 0.4 хувиар өссөн байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Тус компани нь тайлант онд 232,338.4 сая төгрөгийн борлуулалтын өртөгтэй ажилласан байгаа нь өмнөх оны дүнгээс 20,319.1 сая төгрөгөөр өссөн байгаад борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн өсөлттэй уялдсан түлшний зардлын өсөлт, ажилчдын цалингийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Хувьсах зардал буюу түлшний зардал төлөвлөгөөнөөс 1,029.0 сая төгрөгөөр өссөн, ашиглалтын зардал 447.4 сая төгрөгөөр өссөн ба нийтдээ үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөтэй харьцуулахад 587.5 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн бус үйл ажиллагаанаас 9,924.1 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөтэй харьцуулахад 6,541.2 сая төгрөгөөр өссөн ба 4,870.3 сая төгрөгийн зардалтай ажилласныг төлөвлөгөөтэй харьцуулан үзэхэд 1,487.5 сая төгрөгөөр буурсан байна. Үйл ажиллагааны бус орлогын өсөлтөд “Турбин агергат 7” хөрөнгийг орлогын аргаар бүртгэсэнтэй холбоотой хандив тусламжийн орлогын өсөлт нөлөөлсөн.

2.7 Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад тус байгууллага нь өөрийн веб сайтандаа шилэн дансны www.shilendans.gov.mn мэдээллийг бүрэн оруулсан байна.

Тайлант онд Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 29 дүгээр тогтоолын хавсралт журмын дагуу мэдээллийг байршуулсан байдал 100 хувь, мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байдал 95 хувь байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 36 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 93 горим, сорил гүйцэтгэв.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, орлого, өртөг, цалингийн зардал, үйл ажиллагааны бус орлого, зардал зэрэг дансад ажил гүйлгээ, үлдэгдэл тооцоолуудыг түүвэрлэн нарийвчилсан горим сорилын аргаар шалгалаа.

Мөн мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлийг тулган шалгах, авлага өглөгийн үлдэгдлийг тулган баталгаажуулалтаар нотлох, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хяналтын түүвэр тооллого хийх, тодорхой ажил гүйлгээг түүвэрлэн сорил хийн шалгах, орлого, өртгийн дүнд шинжилгээ хийх, таамаглах, хөрөнгийн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу хийж буй эсэхэд түүвэрлэн сорил хийн шалгах, батлагдсан төлөвлөгөө рүү тулган шалгах, татвар нийгмийн даатгалын тайлангуудыг нэгтгэн холбогдох данс руу хөөн шалгах зэрэг горимыг гүйцэтгэн түүний үр дагаврыг 2.11, 2.13-т хураангуйлан тэмдэглэв.



Олж тогтоосон эрсдлийн үр дагаврыг тодорхойлвол:

- Авлага, өглөгийн дансны хувьд насжилтын тайлан гаргаж судалгаа хийгээгүй байх, найдваргүй авлагын нөөцийг байгуулах хувь хэмжээг үндэслэлгүй тогтоосон байх, найдваргүй авлагын нөөцийн тооцооллыг буруу хийх, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байх, зөв ангилан бүртгээгүй байх зэрэг эрсдлүүд байж болзошгүй гэж тогтоосны дагуу дансны нарийвчилсан сорил гүйцэтгэж санхүүгийн тайланд ангилал зөрүүлэн бүртгэсэн 11,105.4 сая төгрөгийн өглөгийг залруулан бүртгэсэн.
- Бараа материалын худалдан авалтын болон зарцуулалтын өртгийн тооцоог зөв тооцохгүй байх, бараа материалын дансанд хэрэгцээ шаардлага хангахгүй, насжилт өндөртэй бараа материал байх, бараа материалын тооллого хийгээгүй байх, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байх, бараа материалын үнэ цэнийн бууралтыг бүртгээгүй байх, бараа материалын худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, худалдан авалтын журмыг мөрдөөгүй хийх эрсдэл үүсч болзошгүй гэж үзсэн. Олж тогтоосон эрсдэлийн дагуу дансны нарийвчилсан горим гүйцэтгэж 1,058.5 сая төгрөгийн залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, 676.5 сая төгрөгийн зөвлөмжийг удирдлагад хүргүүлсэн.
- Үндсэн хөрөнгө элэгдүүлэх хугацааг НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-д заасны дагуу тогтоогоогүй байх, үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй байх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө худалдан авах, үндсэн хөрөнгийн элэгдэл болон их засварыг буруу тооцон бүртгэх, үндсэн хөрөнгийн өртгийг буруу тооцох, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байх, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байх, эрх бүхий байгууллагын шийдвэргүй хөрөнгө данснаас хасах зэрэг эрсдэл байж болзошгүй гэж төлөвлөлтийн үе шатанд тогтоосны дагуу нарийвчилсан горим, сорил гүйцэтгэж үндсэн хөрөнгийн дансанд 472.8 сая төгрөгийн залруулгыг хийж, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 1,220.0 сая төгрөгийн зөвлөмжийг компанийн удирдлагад хүргүүлсэн.
- Урт болон богино хугацаатай зээлийн өглөгийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдэх, гадаад валютаар үүссэн өглөгт ханшийн тэгшитгэл хийгээгүй байх, хүүгийн зардал өглөгийг илүү, дутуу бүртгэх эрсдэл байж болзошгүй гэж аудитын төлөвлөлтийн үед тогтоон аудитын горим сорилыг гүйцэтгэн санхүүгийн тайланд 1,057.4 сая төгрөгийн залруулгыг хийсэн.
- Цалингийн зардлын хувьд батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулах, нийгмийн даатгал, татварын тайлангаас зөрөх, илүү цагийн хөлс болон бусад нэмэгдэл шагнал урамшууллыг зөв бүртгэхгүй байх, бусад нэмэгдэл урамшууллыг хамтын гэрээ болон бусад хууль тогтоомж зөрчин олгох зэрэг эрсдэл байж болзошгүй гэж үзэн аудитын нарийвчилсан сорил горимыг хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн тайланд 7,479.0 сая төгрөгийн жилийн үр дүнгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг залруулж, 2 зөвлөмжийг удирдлагад хүргүүлсэн.
- Компани нь хөрөнгө худалдан авах үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийж буй эсэхэд түүвэр хийн нарийвчилсан горим сорилыг гүйцэтгэж цаашдын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн.



2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

- ✚ Монгол Улсын Засгийн газрын бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц”-ын суурилагдсан хүчин чадлыг 120 МВт-аар өргөтгөх төслийн хүрээнд суурилуулсан “Турбин агергат 7”-г хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 05 дугаар тогтоолоор НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулга”-ын капиталын аргаар төрийн өмчийг 119,151.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн боловч Эрчим хүчний зохицуулах хорооноос 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр улсын төсвийн санхүүжилтийг капиталын аргаар бүртгэх тохиолдолд “Турбин агергат 7” хөрөнгийн элэгдлийн зардлыг тарифт суулгах боломжгүй гэж үзэн орлогын аргаар бүртгэх талаар тус компанид 60-07-004/04 тоот албан шаардлага ирүүлсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны албан шаардлага болон энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх тухайд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А-1/730 тоот албан бичгээр өгсөн удирдамжийг үндэслэн ТУЗ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Турбин агергат 7”-г НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулга”-ын орлогын аргаар бүртгэхийг гүйцэтгэх захирал С.Анхбаярт зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг даалгасан байна.


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 30 дугаар тогтоолын дагуу компани нь “Турбин агергат 7” хөрөнгийг НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулга”-ын орлогын аргаар залруулан бүртгэснээр төрийн өмч 119,151.9 сая төгрөгөөр буурч, урт болон богино хугацаат хойшлуулсан орлогыг нэмж бүртгэсэн.

- ✚ Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2014 онд хэрэгжсэн “**210 МВт-ын хүчин чадалтай уур усны дулаан солилцуур бүхий дулааны дэд станц**”-ын төслийн ажил дуусч 2014 оны 11-р сараас Улсын комисс ажиллаж 2015 оны 9-р сарын 25-ны өдөр 10,604.3 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн хэдийч энэхүү дэд станцыг хэрэглэгчдэд хүргэх гол дамжуулах шугам буюу траст, холбогдох зарим тоноглолын асуудлыг бүрэн шийдээгүй, төслийг хэрэгжүүлэхэд тооцоолсон хэрэглэгчгүй, төслийг цогцоор нь шийдээгүй зэргээс 10,604.3 сая төгрөгийн хөрөнгө бүрэн ашиглалтгүй, эдийн засгийн үр, өгөөжгүй хөрөнгө болсон байна.

Мөн Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх II төслийн хүрээнд Сангийн яамны дамжуулан зээлдүүлэх ХБНГУ-ын зээлийн эх үүсвэрээр авсан 1,058.5 сая төгрөгийн Насос ПЭН тоног төхөөрөмжтэй холбоотой бусад хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс энэхүү хөрөнгө хэзээнээс ашиглалтанд орж эдийн засгийн үр өгөөжөө өгөх нь тодорхойгүй байна.

2.10 Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 онд завсрын аудит хийгдээгүй байна.



2.11 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.11.1 Эрчим хүчний үр ашиг II төслийн хүрээнд хүлээн авсан тоног төхөөрөмжийн бүртгэл, тайлагналын талаар

Бараа материалын дансанд Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх II төслийн хүрээнд сонгон шалгаруулалтаар авсан 1,058.5 сая төгрөгийн Насос ПЭН тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийг бүртгэсэн нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, НББОУС 2 “Бараа материал”-ын хүлээн зөвшөөрөлт, шалгууртай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн зарчим, хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, шалгуурын дагуу бараа материалын дансыг 1,058.5 сая төгрөгөөр бууруулан, бусад эргэлтийн бус хөрөнгийн дансыг уг дүнгээр нэмэгдүүлэх залруулгыг санал болгон санхүүгийн тайланд тусгасан.

2.11.2 Гэрээний дагуу тооцон бүртгэх зээлийн хүүгийн зардал, өглөгийн тухайд

Аудитын хүрээнд санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа хүүтэй зээлийн өглөг, хүүгийн зардал, өглөгийг зээлийн гэрээ, төлбөрийн хуваарьтай тулган шалгаж, хүүгийн тооцооллыг давтан хийж компанийн бүртгэлтэй тулган шалгахад дараах зөрүү үүссэн.

- ✚ Сангийн ямаар дамжуулан авсан МОН Р6 төслийн зээлийн хүүгийн зардлыг 192.3 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн өглөгийг 156.6 сая төгрөгөөр дутуу, урьдчилж төлсөн хүүгийн төлбөрийг 35.7 сая төгрөгөөр илүү,
- ✚ Сангийн ямаар дамжуулан авсан МОН Р3 төслийн зээлийн хүүгийн зардлыг 306.1 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн өглөгийг 99.6 сая төгрөгөөр дутуу, урьдчилж төлсөн хүүгийн төлбөрийг 206.5 сая төгрөгөөр илүү,
- ✚ УБДС ТӨХК-иар дамжуулан авсан МОН1548 төслийн зээлийн хүүгийн зардлыг 27.2 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн өглөгийг 5.9 сая төгрөгөөр тус тус дутуу, урьдчилж төлсөн хүүгийн төлбөрийг 21.3 сая төгрөгөөр илүү,
- ✚ Сангийн ямаар дамжуулан авсан Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх II төслийн зээлийн хүүгийн зардлыг 492.4 сая төгрөгөөр, хөрөнгийн өртөгт капиталжих хүүгийн төлбөрийг 13.2 сая төгрөгөөр, өнгөрсөн тайлант жилийн хүүгийн зардлыг 39.3 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн өглөгийг 544.9 сая төгрөгөөр дутуу тус тус тайлагнасан байна.

Дээрх зөрүү нь эрх ба үүрэг, үнэн зөв, тохиолдсон байх гэсэн шалгуурыг хангаагүй төдийгүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 <<Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө>> гэсэн заалтыг зөрчихөд хүрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: НББОУС 23 “Зээлийн өртөг”-ийн дагуу насос ПЭН хөрөнгийн өртөгт 13.2 сая төгрөгийг хуримтлуулан, тайлант хугацаанд хамаарах хүүгийн зардлыг 732.3 сая төгрөгөөр, хүүгийн өглөгийн дансыг 807.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, өнгөрсөн тайлант хугацаанд хамаарах 325.1 сая төгрөгийн хүүгийн зардлыг хуримтлагдсан ашгийн дансыг, 263.5 сая төгрөгөөр урьдчилж төлсөн хүүгийн төлбөрийг бууруулах залруулгыг санал болгон санхүүгийн тайланд залруулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.11.3 Санхүүгийн байдлын тайлангийн тайлагнал, өр төлбөрийн ангиллын талаар

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн бэлтгэн бидэнд танилцуулсан 2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд 9,264.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх дүн буюу богино хугацаат зээлийн өглөгийг бусад богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасан. Мөн 1,310.4 сая төгрөгийн хүүгийн өглөгийг дансны өглөгөөр, 530.8 сая төгрөгийн нөөц ба өр төлбөрийг бусад богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасан байгаа нь санхүүгийн тайлан хэрэглэгчдийг зөрүүтэй мэдээллээр хангахад хүрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан маягт”-ын дагуу ангилан залруулан тайлагнасан.

2.11.4 Жилийн үр дүнгийн шагналын тухайд

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний 3 дугаар зүйлийн 3.9.2 заалт, ТУЗ-ийн 2017 оны 2-р сарын 22-ны өдрийн 07 дугаар тогтоол, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн “Үйлдвэрийн үр дүнгээр шагнал олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 алба, хэлтэс, цех, тасгийн 2016 оны жилийн ажлын тайлан дүгнэх комиссын үнэлгээг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2017 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар компанийн ажилчдад 2016 оны жилийн ажлын үр дүнгийн шагналд 4,353.5 сая төгрөг олгож тайлант хугацааны зардлаар бүртгэсэн.


Мөн “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний 3 дугаар зүйлийн 3.9.2 заалт, ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 34 дүгээр тогтоол, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн “Үйлдвэрийн үр дүнгээр шагнал олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 алба, хэлтэс, цех, тасгийн 2017 оны жилийн ажлын тайлан дүгнэх комиссын үнэлгээг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/452 дугаар тушаалаар компанийн ажилчдад жилийн ажлын үр дүнгийн шагналд 5,362.3 сая төгрөг олгохоор шийдвэрлэснээс 3,106.4 сая төгрөгийг олгож тайлант хугацааны зардлаар бүртгэсэн ба үлдэгдлийг тайлант оны зардлаар хуримтлуулж бүртгээгүй байна.

“Дулааны цахилгаан станц 4” ТӨХК нь өнгөрсөн тайлант жилүүдэд тухайн жилийн үр дүнгийн шагналыг дараагийн тайлант жилд олгох шийдвэрийг гарган, дараагийн тайлант жилд олгон зардлаар хүлээн зөвшөөрч ирсэн.

Тайлант 2017 оноос тус компани нь жилийн үр дүнгийн шагналыг тухайн жилдээ олгож, зардлаар хүлээн зөвшөөрөх бодлого баримталж эхэлсэнтэй холбоотой тайланд жилд өнгөрсөн тайлант хугацаа буюу 2016 оны жилийн үр дүнгийн шагнал, тайлант жил буюу 2017 оны жилийн үр дүнгийн шагналыг бүртгэх болсон байна.

Өөрөөр хэлбэл компани нь ТУЗ-ийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу жилийн үр дүнгийн шагналыг бүртгэж тайлагнахдаа компанийн ажиллагсдад олгосон дүнгээр зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэснээр тайлант хугацааны зардал цэвэр дүнгээрээ 2,359.9 сая төгрөгөөр илүү тайлагнахад хүрсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 <<жинхэнэ хэрэгжилтийн>>, 5.1.4 <<үнэн зөв байх>> гэсэн зарчмуудыг зөрчихөд хүрсэн.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн уялдаат зарчмын дагуу 2016 оны жилийн үр дүнгийн шагнал болох 4,353.5 сая төгрөг болон холбогдох 565.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг хуримтлагдсан ашгийн дансанд, 2017 оны дутуу бүртгэсэн жилийн үр дүнгийн шагнал болох 2,245.2 сая төгрөг холбогдох 314.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг хүлээн зөвшөөрч тайлант жилийн зардал, өглөгөөр тус тус залруулан бүртгэсэн.



2.11.5 Бараа материалын худалдан авалтын талаар

Тайлант хугацаанд худалдан авсан сэлбэг хэрэгсэл, бусад материалын үнийн дүнгийн 30 орчим хувийн худалдан авалтын тоо хэмжээ, үнийн дүн, нийлүүлэлтийн хугацааг холбогдох гэрээ, сонгон шалгаруулалтын материал руу тулган шалгахад гэрээ, сонгон шалгаруулалтын үед нийлүүлэхээр амласан хугацаа хоцрох байдал нийтлэг ажиглагдсан.

Компани гэрээний хэрэгжилтийг дүгнэн зарим харилцагчид гэрээний хариуцлага тооцож алданги, торгууль ногдуулж байгаач зарим харилцагчдад гэрээний алданги, торгууль ногдуулаагүй байна. Бидний түүвэрт орсон худалдан авалтын 8 хувь буюу 676.5 сая төгрөгийн үнийн дүнтэй худалдан авалт гэрээний хугацаа хоцорсон байгаач алданги торгууль ногдуулаагүй байсан.

Шийдвэрлэсэн; Компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх;

2.11.6 Үндсэн хөрөнгийн худалдан авалт, бүртгэлийн тухайд

Аудитын хүрээнд тайлант хугацаанд нэмэгдсэн үндсэн хөрөнгийн орлогын бүртгэлийг батлагдсан төсөв төлөвлөгөө, эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэр, холбогдох анхан шатны баримт, анхны өртгийн тооцоолол руу тулган шалгахад дараах зөрчилүүд илэрсэн.

- ✚ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөгдөөгүй туслах тоноглолын урсгал засвараар төсөвлөгдсөн 108.6 сая төгрөгийн /8 нэр төрлийн 29 ширхэг/ үндсэн хөрөнгийг, мөн бусад төлөвлөгөө буюу БҮТЭЗ, сэлбэг материалд төлөвлөгдсөн 83.5 сая төгрөгийн /57 нэр төрлийн 218 ширхэг/ хөрөнгийг бараа материалаар дамжуулан үндсэн хөрөнгийн орлогод авсан байна,
- ✚ Үндсэн хөрөнгийн ангилал залруулсан бичилтүүд анхан шатны баримтад гүйлгээний утга дээр акталсан гэсэн бичигтэй байгаа нь мэдээллийг буруу илэрхийлж байна


Хөрөнгийг зориулалтын бус санхүүжилтээр хийх нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төлөвлөгөөний биелэлт зөрүүтэй илэрхийлэгдэх ба Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24.2 дугаар зүйл <<Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах>> гэсэн заалтыг зөрчихөд хүрсэн.

Шийдвэрлэсэн; Компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх;

2.11.7 Тоног төхөөрөмжид хийсэн их засвар, түүний бүртгэл

“Дулааны цахилгаан станц 4” ТӨХК нь тайлан онд 24,801.4 сая төгрөгийн их засварыг гүйцэтгэж хөрөнгийн дүнд капиталжуулан бүртгэсэн. Аудитын хүрээнд хөрөнгийн их засварыг батлагдсан төсөв, холбогдох анхан шатны баримт руу хөөн шалган үзэхэд хөрөнгийн ажиллагааг шалган их засвараас хүлээн авсан акт, материал ажлын хөлсний гүйцэтгэлийн актууд үйлдэн хүлээн авсан хугацаанаас хойш дахин тухайн хөрөнгийн их засварын дүнд материал зарцуулсан гэж бараа материал зарлага болгон их засварт бүртгэж байна. Тухайлбал: Зуух №1-д хийсэн их засварыг 2017 оны 7 дугаар сард их засвараас хүлээн авсан актууд үйлдэн хийж дуусгасан баримтууд байгаа хэдийч 2017 оны 9 дүгээр сард нэмж 263.4 сая төгрөгийн, 12-р сард 128.3 сая төгрөгийн материал зарцуулсан гэж бүртгэсэн. Бидний түүвэрт хамрагдсан их засварын хувьд нийт дүнгээрээ 543.5 сая төгрөгийн материалыг нэмж бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн; Компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх;



2.11.8 Үндсэн хөрөнгийн элэгдэл

Компанийн тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардлыг давтан тооцоолол хийн шалган үзэхэд 15 төрлийн тоног төхөөрөмжид 472.8 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн; Санхүүгийн тайланд элэгдлийн зардал, хуримтлагдсан элэгдлийг 472.8 сая төгрөгөөр нэмж бүртгэн санхүүгийн тайланд залруулгыг тусгасан.

2.11.9 Үлдэгдэл өртөгтэй боловч ашиглагдахгүй байгаа хөрөнгийн тухайд

Компанийн үндсэн хөрөнгийн дансанд 4,116.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 3,632.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 484.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий компанийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй хөрөнгүүд байгаа боловч компани НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 51 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа, үлдэгдэл өртгийг хянаагүй зөрчил байна.

Шийдвэрлэсэн; НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн дагуу жил бүр хөрөнгийн ашиглалтын хугацаа үлдэх өртгийг тооцон хянаж байх тухай зөвлөмж хүргүүлэх.

2.11.10 Дуусаагүй төслийн дансны үлдэгдэлийн тухайд

Дотоод циклийн усыг “Эсрэг осмос + цахилгаан деионизаци”-ийн технологиор бэлтгэх төслийг тайлант онд хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн хэдийч тус төслийн дансанд 112.0 сая төгрөгийн төлбөрийг бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн; Санхүүгийн тайланд бусад эргэлтийн бус хөрөнгө дансыг 112.0 сая төгрөгөөр бууруулж, урьдчилж төлсөн төлбөрийн дансанд бүртгэсэн.

2.11.11 Худалдан авах үйл ажиллагааны тухайд

“Дулааны цахилгаан станц 4” ТӨХК-ийн худалдан авах үйл ажиллагааг тайлант онд судалгаа хөгжлийн алба, засварын алба, худалдан авах ажиллагааны хэлтэс зохион байгуулсан. Аудитын явцад худалдан авалтаас түүвэр хийн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг шалгахад борлуулалтын орлого ТӨХ-д тусгасан дүнд хүрээгүй, татварын тодорхойлолтын хүчинтэй хугацаа тендер ирүүлэх хугацаанаас зөрсөн, шүүхийн төрөлжсөн архиваас Иргэний хэргийн тодорхойлолт аваагүй, Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт хугацаа дууссан, бараа нийлүүлэх хугацаа нийцээгүй, аудитын дүгнэлтгүй байх, ТӨХ-ийг алдаатай боловсруулсан, тендерт оролцогчид гомдол гаргах зэрэг зөрчилүүд гарсан байна.

Шийдвэрлэсэн; Компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх;



2.11.12 Шатахууны үлдэгдэл баталгаажуулах тухайд

Шатахууны тайланг шатахууны төрлөөр бэлтгэн гаргадаггүй, 1-ээс 8 дугаар сар хүртэл картаар авсан шатахууны тооцоог нийлүүлэгч байгууллагатай сар бүр үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасан ерөнхий нягтлан бодогч нь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн; Компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх;

2.11.13 Худалдан авсан шатахууны үнэ, тоо хэмжээний тухайд

Шунхлай трейдинг ХХК-иас авто бензин, дизель түлшийг худалдан авахдаа тус компанитай байгуулсан Д/2016-314, Т/406, Д/2016-315, Т/402 тоот гэрээгээр урьдчилан тохирсон (сонгон шалгаруулалтын) гэрээний үнэ болон гэрээнд заасан тоо хэмжээнээс илүүгээр худалдан авсан тохиолдол үүссэн байна.

Аудитын тооцоолсоноор тус гэрээний нэгжийн үнээс 4.2 сая төгрөгөөр илүү дүнгээр, А-80 автобензинийг гэрээний тоо хэмжээнээс 12.4 тонн буюу 17.2 сая төгрөгөөр, Дизель түлшийг гэрээний тоо хэмжээнээс 14 тонн буюу 20.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн худалдан авсан байна.

Шийдвэрлэсэн; Компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлэх


2.11.14 Үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох сар бүрийн шагналт цалин

Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.4 дэх заалт, "Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан "Хамтын гэрээ"-ний 3 дугаар зүйлийн 3.9.1 дэх заалтыг үндэслэн, Гүйцэтгэх захирлын 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаарын тушаалаар батлагдсан "Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам"-ын дагуу 2017 онд 7,618.7 сая төгрөгийн сарын үр дүнгийн шагнал олгосон байна. Аудитын хүрээнд сар бүрийн шагналт цалин олгох журам, үндэслэл, олгосон байдлыг хянан үзэхэд тухайн сард 1 хоног ажилласан хүн, шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн, үйлдвэрлэлийн бус хэлтэс цехийн ажилтны ялгаагүй сар бүрийн шагналт цалинг нийтэд нь хавтгайруулж олгож байгаа байдал ажиглагдсан.

Шийдвэрлэсэн; Сар бүрийн шагналт цалин олгох "Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам"-ыг хянаж үзэх

2.11.15 Хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан гэрээт ажилчдын тухайд

Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д зааснаар "байнгын ажлын байр" гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүргийг хэлнэ гэж заасан бөгөөд мөн энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс тэрийн аудитын байгууллага бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэж заасан байна.



“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2017 оны 134 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа ба эдгээрийн зарим иргэдтэй байгуулсан гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн; Зөвлөмж

2.11.16 Бараа материалын зарцуулалтын өртөг

Аудитын ажлын хүрээнд бараа материалын зарцуулалтын дундаж өртгийн тооцооллыг түүвэрлэн шалгахад зарим барааны зарцуулалтын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар зарлага болгохгүй, түүнээс зөрүүтэйгээр зарлага болгож байгаа байдал гарч байна. Тухайлбал: [1103010320] барааны кодтой Холхивч SKF 22238 сск/w 33 3.6 сая төгрөгийн өртөгтэй 6 ширхэг үлдэгдэлтэй байсан. Нэмж 1 ширхэг 3.4 төгрөгөөр худалдан авахад дундаж өртөг 3.6 сая төгрөг болох байтал компанийн бүртгэлээр 3.4 сая төгрөг байна. Мөн тухайн сард өөр өөр үнээр худалдан авсан шатахууны өртгийг тооцоходоо эхний худалдан авалтын үнээр зардалд бүртгэх тохиолдол ажиглагдлаа. Энэхүү алдаа нь тухайн барааны эцсийн үлдэгдлийг илүү дүнгээр, зарцуулалтын өртгийг дутуу дүнгээр илэрхийлэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Бараа материалын 5.2 дугаар заалтыг зөрчихөд хүргэж байна.

Шийдвэрлэсэн; Зөвлөмж хүргүүлэх

2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Монгол Улсын Улсын Их Хурлаас 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай гаргасан 69 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хянан үзэхэд,

2015 онд нийт өр төлбөр 111,222.9 сая төгрөг, 2016 онд нийт өр төлбөр 120,446.5 сая төгрөг байсан ба тайлант онд 233,779.7 сая төгрөг болж өссөн байна. Үүнээс хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр “Турбин агергат 7” хөрөнгийг НББОУС 20 “Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулга”-ын орлогын аргаар залруулан бүртгэсэн хойшлуулсан орлогын дүнг хасч тооцоход нийт өр төлбөр 123,649.6 сая төгрөг болж 2015 оны дүнгээс 12,488.5 сая төгрөг, 2016 оны дүнгээс 3,264.9 сая төгрөгөөр өссөн байгаа нь тогтоолын 4.2 << 2015 жилийн эцсийн санхүүгийн тайлангаар баталгаажуулсан өглөгийг бууруулах>>,

2017 онд 1486 ажилтантай байгаа нь тогтоолын 4.3 <<...ажиллагсадын тоог бууруулах. 2012 (1462) оны түвшинд хүргэх.>> гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хөрөнгийн үнэлгээ-Тус компанийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг 2008 онд “Итгэлт аудит” ХХК хийснээс хойш үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй, 2012 онд “Үндэсний реалти” ХХК хөрөнгийн дахин үнэлгээ хийх гэрээ байгуулан ажилласан боловч хөрөнгийн бүртгэлийг ERP системд шилжүүлж тоног төхөөрөмжийн ангиллыг шинээр хийж хөрөнгийг задалж бүртгэх болсонтой холбоотойгоор тоног төхөөрөмжийн үнэлгээг дээрх ангиллаар хийх болсон ба хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тест хийх болсонтой холбоотойгоор нэмэлт судалгаа, хөрөнгө зарцуулах шаардлагатай болж хойшлуулсаар 2016 онд 2012 оны хөрөнгийн үлдэгдэлд хийсэн үнэлгээний тайланг өгснөөр энэхүү хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах боломжгүй болсон байна. Өөрөөр хэлбэл компанийн үндсэн хөрөнгийн дүнд 2008 оноос хойш үнэлгээ хийгдээгүй, хөрөнгө санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй байна.

Тайлант 2017 оны байдлаар тус компанийн санхүүгийн байдлын тайланд 1731 ширхэг 91,820.0 сая төгрөгийн компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох шагналт цалин- Аудитор сар бүрийн шагналт цалинг нийтэд нь хавтгайруулан олгож байна гэж үзэн “Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах, шагнал олгоход тавих шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгах зөвлөмжийг хүргүүлсэн байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэлийн 21,298.3 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,938.4 сая төгрөгийн залруулагдаагүй материаллаг бус зөрчилд 9-н зөвлөмж хүргүүлэв.

2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Гроут финанс аудит ХХК Үндэсний аудитын газрын захиалгаар аудит хийж, хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Өмнөх оны аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй, 15,781.5 сая төгрөгийн 4-н албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилтийг төлөвлөлтийн явцад хянан үзэхэд 9,442.5 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжсэн боловч өмнөх жилүүдийн аудитаар Хөргөх цамхаг-4 хөрөнгөнд гарсан эвдрэл гэмтлийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн дагуу шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хандан хөрөнгийн асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлэн ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Тайлант онд Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн Хөргөх цамхаг-4 хөрөнгөнтэй холбоотой зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 18-н зөвлөмж өгсөн байгаа бөгөөд зөвлөмжийн биелэлтийг эргэн хянахад 79 хувьтай, 12 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн, 3 зөвлөмж хэрэгжих шатандаа, бусад зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

- ✚ Бараа материалын нөөцийг зохистой бүрдүүлэх, хэрэгцээнээс илүү бараа материалын нөөц бий болгохгүй байх үүдээс сэлбэг хэрэгсэл, материал үнэт зүйлсийн захиалга, татан авалтын төлөвлөлтийг сайжруулах үлдэгдлийг зохистой түвшинд байлгахад анхаарах, тайлант жилийн эцсээр хөдөлгөөн огт гараагүй, хөдөлгөөн удаантай сэлбэг хэрэгсэл, материалын үлдэгдэлд удирдлагын зүгээс дүн шинжилгээ хийж хөдөлгөөн гараагүй ашиглахгүй удсан сэлбэг хэрэгслийн шалтгааныг тогтоож худалдан борлуулах, хэрэгцээтэй салбар нэгжүүдэд шилжүүлэх, хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материалыг актлах зэргээр эргэлтэнд оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах зөвлөмжийг хүргүүлсэн боловч энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- ✚ Эрчим зоогийн газар нь 1,436.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байгаа нь компанийн алдагдал өсөхөд нөлөөлж байгаа учир хоолны үнийг бодитой тооцох, өртөг зардлыг брдитой тооцож, компанийн алдагдлыг бууруулах бодлого барьж ажиллах гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨТ ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

- Компанийн 2016 оны батлагдсан орон тоо 1492, гүйцэтгэлээр 1477 байсан ба хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан 113-н гэрээт ажилчид батлагдсан орон тоонд ороогүй бөгөөд эдгээр ажилчдад олгосон цалин хөлсийг их засварт бүртгэж байна. Их засварын үед хөлсөөр ажиллах гэрээ байгуулдаг гэж байгаа ч гэрээт ажилтан байгаагийн үндэслэл, хэрэгцээ шаардлагыг эргэн хянах зөвлөмж хүргүүлсэн боловч тайланд онд хөлсөөр ажиллах гэрээг 134 болж өссөн байна.

2.16 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

СТА-А-4 маягтыг ашиглан материаллаг байдлын суурь болон 2017 оны Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт борлуулалтын орлогыг суурь болгон сонгох нь зохимжтой гэж үзсэн.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн борлуулалтын орлого 233,272.8 сая төгрөг бөгөөд төлөвлөлтийн үе шатанд түүний 0.5 хувь буюу 1,166.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд хэвээр тогтоолоо.

2.17 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БЯМБА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.МӨНХТОГТОХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ДАВААСҮРЭН



3. Менежментийн захидал

Аудит нь бүхэлдээ санхүүгийн тайланд дүгнэлт гаргах боломжийг бидэнд бүрдүүлэхэд чиглэдэг бөгөөд тухайн зорилгын хүрээнд компанийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийн зохистой байдлыг авч үздэг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын компанийн аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн холбогдох ажилтанд талархал илэрхийлье.



3.1 Худалдан авах үйл ажиллагааны тухайд

Тэргүүлэх ач холбогдол 1

Ажиглалт

“Дулааны цахилгаан станц 4” ТӨХК-ийн худалдан авах үйл ажиллагааг тайлант онд судалгаа хөгжлийн алба, засварын алба, худалдан авах ажиллагааны хэлтэс зохион байгуулсан. Аудитын явцад худалдан авалтаас түүвэр хийн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг шалгахад борлуулалтын орлого ТӨХ-д тусгасан дүнд хүрээгүй, татварын тодорхойлолтын хүчинтэй хугацаа тендер ирүүлэх хугацаанаас зөрсөн, шүүхийн төрөлжсөн архиваас Иргэний хэргийн тодорхойлолт аваагүй, Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт хугацаа дууссан, бараа нийлүүлэх хугацаа нийцээгүй, аудитын дүгнэлтгүй байх, ТӨХ-ийг алдаатай боловсруулсан, тендерт оролцогчид гомдол гаргах зэрэг зөрчилүүд гарсан байна.

Эрсдэл

Хууль эрх зүйн актыг мөрдлөг болгоогүйгээс эрх бүхий байгууллага хариуцлага хүлээлгэх

Зөвлөмж

“Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн заалтыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлэх. Тендерийн урилгад худалдан авах бараа бүтээгдэхүүний агуулгыг ойлгомжтой байдлаар хүргэх, засварын ажлын цаг хугацаанд баригдаж шаардлага хангаагүй оролцогчийг сонгохгүй байх, тендерийн баримт бичиг болон ТӨХ-ийг алдаагүй бэлтгэх, бараа нийлүүлэх хугацааг оновтой тогтоох зэргээр худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журмын дагуу борлуулалтын орлого ТӨХ-д тусгасан дүнд хүрээгүй, татварын тодорхойлолтын хүчинтэй хугацаа тендер ирүүлэх хугацаанаас зөрсөн, шүүхийн төрөлжсөн архиваас Иргэний хэргийн тодорхойлолт аваагүй, Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт хугацаа дууссан, бараа нийлүүлэх хугацаа нийцээгүй, аудитын дүгнэлтгүй байх, ТӨХ-ийг алдаатай боловсруулсан зэрэг зөрчлийг арилган ажиллана.



3.2 Тоног төхөөрөмжид хийсэн их засвар, Тэргүүлэх ач холбогдол 1 түүний бүртгэл

Ажиглалт

“Дулааны цахилгаан станц 4” ТӨХК нь тайлан онд 24,801.4 сая төгрөгийн их засварыг гүйцэтгэж хөрөнгийн дүнд капиталжуулан бүртгэсэн. Аудитын хүрээнд хөрөнгийн их засварыг батлагдсан төсөв, холбогдох анхан шатны баримт руу хөөн шалган үзэхэд хөрөнгийн ажиллагааг шалган их засвараас хүлээн авсан акт, материал ажлын хөлсний гүйцэтгэлийн актууд үйлдэн хүлээн авсан хугацаанаас хойш дахин тухайн хөрөнгийн их засварын дүнд материал зарцуулсан гэж бараа материал зарлага болгон их засварт бүртгэж байна. Тухайлбал: Зуух №1-д хийсэн их засварыг 2017 оны 7 дугаар сард их засвараас хүлээн авсан актууд үйлдэн хийж дуусгасан баримтууд байгаа хэдийч 2017 оны 9 дүгээр сард нэмж 263.4 сая төгрөгийн, 12-р сард 128.3 сая төгрөгийн материал зарцуулсан гэж бүртгэсэн. Бидний түүвэрт хамрагдсан их засварын хувьд нийт дүнгээрээ 543.5 сая төгрөгийн материалыг нэмж бүртгэсэн байна.

Эрсдэл

Хөрөнгө шамшигдах, хөрөнгийг зүй бусаар зарцуулах

Зөвлөмж

Их засвараас хүлээн авсан акт үйлдсэнээс хойш их засварын материал гарч байгаагийн бодит шалтгаан үндэслэлийг тогтоож зохион байгуулалтын арга хэмжээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Их засвараас хүлээн авсан акт, материал ажлын хөлсний гүйцэтгэлийн актууд үйлдэн хүлээн авсан хугацаанаас хойш дахин тухайн хөрөнгийн их засварын дүнд материал зарцуулсан гэж бараа материал зарлага болгон их засварт бүртгэж байгаа асуудлын үндэслэлийг тогтоож удирдлагын шийдвэр, холбогдох нэгжийн актыг гаргуулан ажиллах болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.3 Үндсэн хөрөнгийн худалдан авалт, бүртгэлийн тухайд

Тэргүүлэх ач холбогдол 1

Ажиглалт

Аудитын хүрээнд тайлант хугацаанд нэмэгдсэн үндсэн хөрөнгийн орлогын бүртгэлийг батлагдсан төсөв төлөвлөгөө, эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэр, холбогдох анхан шатны баримт, анхны өртгийн тооцоолол руу тулган шалгахад дараах зөрчлүүд илэрсэн.

- ✚ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөгдөөгүй туслах тоноглолын урсгал засвараар төсөвлөгдсөн 108.6 сая төгрөгийн /8 нэр төрлийн 29 ширхэг/ үндсэн хөрөнгийг, мөн бусад төлөвлөгөө буюу БҮТЭЗ, сэлбэг материалд төлөвлөгдсөн 83.5 сая төгрөгийн /57 нэр төрлийн 218 ширхэг/ хөрөнгийг бараа материалаар дамжуулан үндсэн хөрөнгийн орлогод авсан байна,
- ✚ Үндсэн хөрөнгийн ангилал залруулсан бичилтүүд анхан шатны баримтад гүйлгээний утга дээр акталсан гэсэн бичигтэй байгаа нь мэдээллийг буруу илэрхийлж байна

Эрсдэл

Хөрөнгийг зориулалтын бус санхүүжилтээр хийх нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төлөвлөгөөний биелэлт зөрүүтэй илэрхийлэгдэх ба Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24.2 дугаар зүйл <<Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах>> гэсэн заалтыг зөрчих эрсдэлтэй

Зөвлөмж

Төлөвлөгөөг бодитой, үнэн зөв хийж, төлөвлөсөн зардлаа хэтрүүлэхгүй, төлөвлөгөөний дагуу зарцуулах, түүний хэрэгжилтэд удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллах.

Ажил гүйлгээний утгыг үнэн зөв тусгах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Төлөвлөгөөг бодитой, үнэн зөв төлөвлөн зардлаа хэтрүүлэхгүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төлөвлөгөөний биелэлтийг зөрүүтэй илэрхийлэхгүй байхад анхааран батлагдсан төлөвлөгөө, эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24.2 дугаар зүйлийн дагуу хөрөнгийг худалдан авна.



3.4 Үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох сар бүрийн шагналт цалин

Тэргүүлэх ач холбогдол 1

Ажиглалт

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.4 дэх заалт, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний 3 дугаар зүйлийн 3.9.1 дэх заалтыг үндэслэн, Гүйцэтгэх захирлын 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаарын тушаалаар батлагдсан “Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам”-ын дагуу 2017 онд 7,618.7 сая төгрөгийн сарын үр дүнгийн шагнал олгосон байна. Аудитын хүрээнд сар бүрийн шагналт цалин олгох журам, үндэслэл, олгосон байдлыг хянан үзэхэд тухайн сард 1 хоног ажилласан хүн, шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн, үйлдвэрлэлийн бус хэлтэс цехийн ажилтны ялгаагүй сар бүрийн шагналт цалинг нийтэд нь хавтгайруулж олгож байгаа байдал ажиглагдсан

Эрсдэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 <<төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах>> гэсэн заалтыг зөрчих

Зөвлөмж

Сар бүрийн шагналт цалин олгох “Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.4 дүгээр зүйлд Хамтын гэрээ гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулагдаагүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоо гэж заасан. Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөл буюу хуулиас илүү баталгааг хамтын гэрээнд тусгах үүднээс хамтын гэрээний 3.9.1-д үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох шагналын хувь хэмжээг тогтоосон. Үүний дагуу шагнал олгох босго үзүүлэлт, үр дүнгийн шагнал бууруулах нөхцлийг компанийн Хөдөлмөрийн дотоод журам болон Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журмаар зохицуулан олгодог. Дээрх зөвлөмжийн хүрээнд “Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахад анхааран ажиллана

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.5 Үлдэгдэл өртөгтэй боловч ашиглагдахгүй байгаа хөрөнгийн тухайд

Тэргүүлэх ач холбогдол 2

Ажиглалт

Компанийн үндсэн хөрөнгийн дансанд 4,116.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 3,632.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 484.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий компанийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй, данснаас хасах хөрөнгүүд байгаа бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хорооноос үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг данснаас хасах зөвшөөрөлгүй олгоогүй учир бүртгэсэн хэвээр байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх

Зөвлөмж

НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 51-д хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой ба хэрэв өмнөх тооцоолсноос өөрчлөгдвөл НББОУС 8 дагуу өөрчилж бүртгэхийг заасан. Иймээс энэхүү стандартыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Үндсэн хөрөнгийн дансанд 4,116.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 3,632.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 484.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий компанийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй хөрөнгө нь 2016 оны их засвар, 2017 оны МОН-Р10 төслийн шинэчлэлээр солигдсон. Дээрхи хөрөнгийг актлахаар компанийн ТУЗ-н хуралд 2017 оны 11-р сард оруулсан боловч үлдэх өртөгтэй, компанийн зардалд нөлөөлнө гэсэн шалтгаанаар актлах шийдвэр гаргаагүй болно. 2018 онд ӨХБЗ-н хурлаар хэлэлцүүлэн эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийг гаргуулан ажиллана.



3.6 Бараа материалын худалдан авалтын талаар Тэргүүлэх ач холбогдол 2

Ажиглалт

Тайлант хугацаанд худалдан авсан сэлбэг хэрэгсэл, бусад материалын үнийн дүнгийн 30 орчим хувийн худалдан авалтын тоо хэмжээ, үнийн дүн, нийлүүлэлтийн хугацааг холбогдох гэрээ, сонгон шалгаруулалтын материал руу тулган шалгахад гэрээ, сонгон шалгаруулалтын үед нийлүүлэхээр амласан хугацаа хоцрох байдал нийтлэг ажиглагдсан.

Компани гэрээний хэрэгжилтийг дүгнэн зарим харилцагчид гэрээний хариуцлага тооцож алданги, торгууль ногдуулж байгаач зарим харилцагчдад гэрээний алданги, торгууль ногдуулаагүй байна. Бидний түүвэрт орсон худалдан авалтын 8 хувь буюу 676.5 сая төгрөгийн үнийн дүнтэй худалдан авалт гэрээний хугацаа хоцорсон байгаач алданги торгууль ногдуулаагүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх Компанийн үйл ажиллагаа, тухайлбал засварын ажил төлөвлөсөн хугацаандаа хийгдэхгүй байх.

Зөвлөмж

Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн хяналтыг сайжруулах, гэрээ дүгнэсэн актыг үнэн зөв үйлдэж, үүргийн биелэлтийг дүгнэсний үндсэн дээр төлбөр тооцоог шилжүүлэх талаар удирдлагын зүгээс анхаарч ажиллах нь зүйтэй.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн хяналтыг сайжруулан худалдан авсан сэлбэг хэрэгсэл, материалын тоо хэмжээ, үнийн дүн, нийлүүлэлтийн хугацааг холбогдох гэрээний биелэлт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн төлбөр тооцоог шилжүүлэх тал дээр онцгой анхааран ажиллана. Мөн ERP программын гэрээний бүртгэлийн модульд хөгжүүлэлт хийлгэн сайжруулна.

3.7 Хөлсөөр ажиллах гэрээ

Тэргүүлэх ач холбогдол 2

Ажиглалт

Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д зааснаар “байнгын ажлын байр” гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүргийг хэлнэ гэж заасан бөгөөд мөн энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэж заасан байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2017 оны 134 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа ба эдгээрийн зарим иргэдтэй байгуулсан гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна

Эрсдэл

Хууль эрх зүйн актыг мөрдлөг болгоогүйгээс эрх бүхий байгууллага хариуцлага хүлээлгэх

Зөвлөмж

Компанийн их засварын ажлын үед байгуулж буй хөлсөөр ажиллах гэрээнээс бусад ажилтантай батлагдсан орон тоо хэтрүүлэхгүй байх зорилгоор Хөдөлмөрийн тухай хууль зөрчин хөлсөөр ажиллах гэрээ байгуулахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан ажиллагсдын ажлын хөлс нь тухайн төсөвт ажилд төлөвлөгддөг. Дээрх асуудлаар эрх бүхий байгууллагуудад саналаа танилцуулахад орон тоо нэмж баталдаггүй, мөн компанийн цахилгаан, дулааны эрчим хүч борлуулах үнэ тарифыг санал болгосон үнэ тарифаар баталдаггүй зэрэг сөрөг үр дагавар их байгаагаас байнгын ажлын байранд ажиллуулах боломжгүй. Иймд эрх бүхий дээд байгууллагад асуудлыг танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллана.



3.8 Бараа материалын зарцуулалтын өртөг тооцоолтын талаар

Тэргүүлэх ач холбогдол 2

Ажиглалт

Аудитын ажлын хүрээнд бараа материалын зарцуулалтын дундаж өртгийн тооцооллыг түүвэрлэн шалгахад зарим барааны зарцуулалтын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар зарлага болгохгүй, түүнээс зөрүүтэйгээр зарлага болгож байгаа байдал гарч байна. Тухайлбал: [1103010320] барааны кодтой Холхивч SKF 22238 сск/w33 3.6 сая төгрөгийн өртөгтэй 6 ширхэг үлдэгдэлтэй байсан. Нэмж 1 ширхэг 3,362,466 төгрөгөөр худалдан авахад дундаж өртөг 3.57 сая төгрөг болох байтал компанийн бүртгэлээр 3.4 сая төгрөг байна. Мөн тухайн сард өөр өөр үнээр худалдан авсан шатахууны өртгийг тооцохдоо эхний худалдан авалтын үнээр зардалд бүртгэх тохиолдол ажиглагдлаа. Энэхүү алдаа нь тухайн барааны эцсийн үлдэгдлийг илүү дүнгээр, зарцуулалтын өртгийг дутуу дүнгээр илэрхийлэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Бараа материалын 5.2 дугаар заалтыг зөрчихөд хүргэж байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх

Зөвлөмж

Бараа материалын өртөг тооцоход үүсч буй зөрүүгийн шалтгааныг тодруулж залруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Бараа материалын өртөг тооцоход үүссэн зөрүүгийн шалтгааныг материал тус бүрээр тодруулан ERP програмын санхүүгийн модулийн бараа материалын системийн бүртгэлд нэмэлт хөгжүүлэлт хийлгэн дундаж өртгийн тооцооллын алдааг арилган ажиллана



3.9 Шатахууны худалдан авалт бүртгэлийн тухайд

Тэргүүлэх ач холбогдол 3

Ажиглалт

Шунхлай трейдинг ХХК-иас авто бензин, дизель түлшийг худалдан авахдаа тус компанитай байгуулсан Д/2016-314, Т/406, Д/2016-315 ,Т/402 тоот гэрээгээр урьдчилан тохирсон (сонгон шалгаруулалтын) гэрээний үнэ болон гэрээнд заасан тоо хэмжээнээс илүүгээр худалдан авсан тохиолдол үүссэн байна.

Аудитын тооцоолсоноор тус гэрээний нэгжийн үнээс 4.2 сая төгрөгөөр илүү дүнгээр, А-80 автобензинийг гэрээний тоо хэмжээнээс 12.4 тонн буюу 17,2 сая төгрөгөөр, Дизель түлшийг гэрээний тоо хэмжээнээс 14 тонн буюу 20,5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн худалдан авсан байна.

Мөн шатахууны тайланг шатахууны төрлөөр бэлтгэн гаргадаггүй, 1-ээс 8 дугаар сар хүртэл картаар авсан шатахууны тооцоог нийлүүлэгч байгууллагатай сар бүр үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасан ерөнхий нягтлан бодогч нь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 <<төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах>> гэсэн заалт болон Нягтлан бодогчийн Нягтлан бодох бүртгэлийн хуулиар хүлээх үүрэг, гэрээний заалт зөрчигдөх, компанийн үргүй зардлыг нэмэгдүүлэх

Зөвлөмж

Аудитын үр дүнгээр гаргасан тооцооллын дагуу цехийн зарцуулсан автобензины тооцоог зөрүүг дахин хийж Шунхлай трейдинг ХХК-тай байгуулсан Д/2016-314, Т/406, Д/2016-315 ,Т/402 тоот гэрээний хэрэгжилтийг дахин гаргах

Шатахуун нийлүүлэгч байгууллагатай тооцооны үлдэгдэлийг сар бүр шатахууны төрөл, биет хэмжээ, мөнгөн дүнгээр хийж байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Шатахууны тайланг шатахууны төрөл болон картаар, талоноор худалдан авсан төрлөөр, нийлүүлэгч байгууллага бүрээр сар бүр тооцооны үлдэгдлийн баталгаажуулалт хийн ажиллах болно.

